

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР /МЯГМАР
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-26
	1.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-15
	2.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	15-26

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 08-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газар, Улсын онцгой комиссоос улс орон даяар бүх нийтийн бэлэн байдал тогтоосон тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Байнгын хорооны хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Б.Энх-Амгалан нар Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Улсын Их Хурлын бусад гишүүд байгаа газраасаа MyParliament программ болон онлайн хэлэлцүүлгийн программыг ашиглан Байнгын хорооны хуралдаанд оролцов.

Хуралдаанд оролцвол зохих 19 гишүүнээс 12 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 63.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 43 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Байнгын хорооны энэ өдрийн хуралдаанаар хэлэлцэх Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэхийг ирэх 7 хоног хүртэл хойшлуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Шүүхийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэхийг хойшлуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Шүүхийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулав.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Нэг. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, С.Бямбацогт, цахимаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, С.Амарсайхан нарын тавьсан асуултад “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Н.Алтанхуяг нар цахимаар үг хэлэв.

С.Бямбацогт: “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн

нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж, цахимаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Д.Ганбат, Ш.Адьшаа, Ш.Раднаасэд нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг цахимаар үг хэлэв.

С.Бямбацогт: Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 1 цаг 30 минут үргэлжилж, 19 гишүүнээс 18 гишүүн оролцож, 94.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан онцгой нөхцөлд хэрэглэх цахим хуралдааны дэгийн дагуу Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны хуралдаанд оролцож байна.

Байнгын хорооны хуралдаанд 12 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Танхимаар 5 гишүүн оролцож байна, 7 гишүүн цахимаар оролцож байна. Ингээд нийт хуралдаанд оролцогчдын олонх хүрэлцэн ирсэн тул өнөөдрийн Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 8-ны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Та бүхэндээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал:

1.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

2.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн анхны хэлэлцүүлэг. Засгийн газар 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Ийм гурван асуудлыг хэлэлцэхээр төлөвлөж байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу? Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Б.Энхбаяр: Өнөөдрийн хэлэлцэх асуудалд багтсан Шүүхийн тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэхийг ирэх 7 хоногийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх ийм горимын саналтай байна. Учир нь Шүүхийн тухай хуулийн ажлын дэд хэсэг өнгөрсөн 7 хоногт Байнгын хорооноос байгуулагдаад ажиллаж байгаа. Ингээд өчигдөр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн хурлаар Шүүхийн тухай хуультай холбогдсон зарчмын шинж чанартай томоохон реформыг Шүүхийн тухай хуульд хийх ёстой. Нэр төдий тийм реформ бол хийгдэхгүй, жинхэнэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг жинхэнэ утгаар нь хангах, шүүх эрх мэдлийн салбарт үүссэн улс төрийн ба шүүхийн дотоод нөлөөллийг үгүй болгох чиглэлд тууштай, зоригтой ийм реформыг хийх ёстой гэдэг бодлогын шийдэл гарсан. Энэ шийдлийн дагуу ажлын хэсэг тодорхой бэлтгэх ажил бас яг одоо хийгдэж дуусаагүй байгаа. Энэний дараа бас Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг бас хуралдах ёстой. Энэ 7 хоногтоо багтаагаад Улсын

Их Хурлынхаа ажлын хэсгийг хуралдуулаад, энэ дэд ажлын хэсгийн хүрээнд яригдсан саналуудыг нэг бүрчлэн хагалж бэлтгэх ийм хугацаа хэрэгтэй байгаа. Тийм учраас ирэх 7 хоногийн Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр хойшлуулах ийм саналтай байна.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Шүүхийн тухай хуультай холбоотой өнгөрсөн 7 хоногт ажлын дэд хэсэг байгуулсан. Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Шүүхийн тухай багц хуулийг хэлэлцэх эсэх нь тодорхойгүй байсан учраас ажлын хэсэг үүнийг хүлээж хугацаа алдсан. Ажлын дэд хэсэг хуралдаж эхэлсэн байгаа. Үндсэн ажлын хэсэг хуралдаж амжаагүй байгаа учраас Байнгын хорооны хуралдаанаар анхны хэлэлцүүлэг хийх боломжгүй гэсэн саналыг ажлын хэсгээс гаргаж байна. Тийм болохоор санал хураалт явуулж хойшлуулах шаардлага үүсэж байна. Санал хураалтыг MyParliament ашиглаж санал хураалт явуулна. Цахимаар орсон гишүүд iPad-аар MyParliament программ ашиглана. Гишүүд цахимаар оролцохдоо өөрсдийнхөө дүрсээ камерт гаргаж хуралдаанд оролцох шаардлагыг манай Тамгын газраас тавьж байна. Өөрийн биеэр оролцож саналаа өгөх ёстой. Камер хаачаад хэн нэг нь цаанаас хуралдаанд оролцох нь хууль зөрчинө гэсэн сэрэмжлүүлэг өгч байна шүү, гишүүдэдээ сануулъя.

Туршилтын санал хураалт явуулъя. Энхбаяр гишүүний гаргасан Шүүхийн тухай хуулийг хойшлуулах саналыг дэмжье гэсэн санал хураалт.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж байна.

Одоо санал хураалтаа явуулъя, ерөнхийдөө болж байх шиг байна. Сэргэлэн, Мөнхцэцэг гишүүд ирцэндээ байгаа байх гэж бодож байна.

Энхбаяр гишүүний гаргасан горимын саналаар Шүүхийн тухай хуулийг өнөөдөр хэлэлцэх асуудлаас хойшлуулья гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Б.БАТГЭРЭЛ